



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН Ц.МӨНХТУЯА ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2025.09.02 № ХЭГ/1364
танай _____-ны № 30 _____-т

**Асуултын хариу хүргүүлэх
тухай**

Танаас “Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох журам”-ын зарим заалтын хэрэгжилт болон Багануур, Багахангай, Налайх дүүргийн төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтнуудын орон нутгийн нэмэгдлийн талаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт заасны дагуу хүргүүлж байна.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫНХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



С.БЯМБАЦОГТ

900255014042

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Г.ЗАНДАНШАТАРТ ТАВЬСАН АСУУЛТЫН ХАРИУ

1.Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн “Тогтоолын хавсралт өөрчлөн батлах тухай” 82 дугаар тогтоолын хавсралтаар өөрчлөн баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам”-ын “2.1.Орон нутагт ажилласны нэмэгдлийг хөдөөгийн сум (тосгон)-д ажиллаж байгаа төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид тухайн эрхэлж байгаа албан тушаалын үндсэн цалингийн 40 хувиар, аймгийн төв болон нийслэлийн алслагдсан Багануур, Багахангай, Налайх дүүрэгт ажиллаж байгаа төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид тухайн эрхэлж байгаа албан тушаалын үндсэн цалингийн 20 хувиар тус тус бодож, сар бүр олгоно” гэсэн заалт хэрэгжихгүй байгаа тухай Багануур, Багахангай, Налайх дүүргийн багш, ажилтнаас ирүүлсэн санал, гомдлын талаар:

-“Тогтоолын хавсралт өөрчлөн батлах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 82 дугаар тогтоолын 2 дах заалтад төрийн албан хаагчдад орон нутагт ажилласны нэмэгдлийг олгоход шаардагдах хөрөнгийг батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлэхийг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасны дагуу Боловсролын яам хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Нийслэлийн алслагдсан Багануур, Багахангай, Налайх дүүрэгт ажиллаж байгаа сургуулийн өмнөх, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага, дүүргүүдийн “Насан туршийн суралцахуйн төв”-ийн багш, ажилтанд орон нутгийн нэмэгдэл хөлсийг тухайн эрхэлж байгаа албан тушаалын үндсэн цалингийн 20 хувиар тооцож 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн олгож байна.

Тухайлбал, Төрийн албан хаагчдын цалингийн нэгдсэн системийн 2025 оны 03 дугаар сарын дата мэдээллээр дээрх тогтоолд заасан нэмэгдлийг Багануур дүүргийн 845 /ТҮБД-562, ТҮ-243, ТҮМ-17, ТҮСБ-5, ТҮЭМ-14, ТЗ-7, цалингийн сүлжээний бус-3/, Багахангай дүүргийн 154 /ТҮБД-59, ТҮ-49, ТҮМ-8, ТҮСБ-3, ТҮЭМ-5, ТЗ-5/, Налайх дүүргийн 1,080 /ТҮБД-658, ТҮМБ-7, ТҮ-353, ТҮМ-32, ТҮСБ-10, ТҮЭМ-19, ТЗ-7/, нийт 2,079 багш, ажилтанд тухайн эрхэлж байгаа албан тушаалын үндсэн цалингийн 20 хувиар бодож олгосон байна.

2.Багануур, Багахангай, Налайх дүүргийн төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага, Насан туршийн суралцахуйн төвийн багш, ажилтнуудын орон нутгийн нэмэгдлийг 2025 оны 09 дүгээр сараас тооцон олгох боломжийн талаар:

-2024 оны төсвийн жилд 4 дүгээр сараас эхлэн Багануур, Багахангай, Налайх дүүргийн хэмжээнд нийт ерөнхий боловсролын 10 сургуулийн цалингийн зардалд 25.4 тэрбум, сургуулийн өмнөх боловсролын 24 байгууллагад 17.3 тэрбум, насан туршийн суралцахуйн 2 төвд 970.6 сая төгрөгийг санхүүжүүлсэн байна.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар ерөнхий боловсролын 11 сургуулийн цалингийн зардалд 26.9 тэрбум, сургуулийн

өмнөх боловсролын 25 байгууллагад 21.9 тэрбум, насан туршийн суралцахуйн 3 төвд 970.6 сая төгрөгийг тус тус батлуулсан. Үүнд орон нутгийн нэмэгдэл багтсан.

Иймд батлагдсан төсвийн хүрээнд тус байгууллагуудын багш, ажилтнуудын орон нутгийн нэмэгдлийг 2025 оны төсвийн жилийг дуустал олгох боломжтой.

3. Багануур, Багахангай, Налайх дүүргийн төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага, Насан туршийн суралцахуйн төвийн багш, ажилтнуудын орон нутгийн нэмэгдлийг Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд хэрхэн тусгаж байгаа талаар:

-Боловсролын салбарын хэмжээнд ажиллаж байгаа нийт албан хаагчдын цалин хөлс болон нэмэгдэл урамшилын зардалд нийт 2.5 их наяд төгрөгийг Монгол Улсын 2026 оны төсвийн төсөлд тусган Улсын Их Хуралд хүргүүлээд байна. Үүнд орон нутагт ажиллаж байгаа ажилтнуудын орон нутгийн нэмэгдэл бүрэн тооцогдож багтсан болно.

---o0o---